



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/406

Номгон

Иргэн Х.Батбаярт газар эзэмшүүлэх  
тухай


“Газрын тухай хууль”-ийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 81 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын Номгон 1 дүгээр баг, Лувсанданзанжанцангийн өргөн чөлөө-5, 5126 тоот хаягт байрлах 37 м2 газрыг иргэн Х.Батбаярт /ВЭ69011178/ дуудлага худалдааны анхны үнийг 2 дахин өсгөн нөхөн төлбөр төлүүлж, худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, эзэмшил газарт Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой эзэмшихийг газар эзэмшигч Х.Батбаярт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.



ДАРГА

Д.МӨНХСАЙХАН